



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/30

Бодь

Ой, хээрийн түймрээс урьдчилан  
сэргийлэх талаар авах зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/90 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ой, хээрийн түймэр гарах эрсдэл бүхий Хөнөг, Уубулан багуудын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Ой, хээрийн түймэр гарч болзошгүй Хөнөгийн заган ой, Хавцгайн хөндий, Цагаан голын хулсны ойролцоо нутагладаг иргэдэд анхааруулга сэрэмжлүүлгийг тогтмол өгч урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах мэдээ мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлж Хөнөгийн Заган ойд морин эргүүлийг тогтмол ажиллуулж ойн сан бүхий газар, авто тээврийн хэрэгсэл нэвтэрч болох газарт зурвас шуудуу татан сэрэмжлүүлэх самбарыг байрлуулан ажиллахыг багийн Засаг дарга (У.Батцэцэг), Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (С.Ганцэцэг), Байгаль хамгаалагч (П.Батбаатар), Улсын тусгай хамгаалалттай газрын Байгаль хамгаалагч (Н.Жаргалсайхан) нарт үүрэг болгосугай.


4. Ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлы зохион байгуулахад шаардагдах, 330.000 (гурван зуун гучин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Эрдэнэцэцэг), Нягтлан бодогч (Б.Батбаяр) нарт зөвшөөрсүгэй.

642201057

5. Ой, хээрийн түймэр унтраах, хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж түймэр гарсан тохиолдолд шуурхай унтрааж удирдлага зохион байгуулалтаар хангаж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Н.Сумъяа/-д даалгасугай.

ДАРГА  Р.БАТЖАРГАЛ

Сумын Засаг даргын 2022 оны 03  
дүгээр сарын 31-ны өдрийн 150 тоот  
захирамжийн 1 дүгээр хавсралт



ЖИНСТ СУМАНД ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ТАЛААР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 03 дугаар сарын 15

Бодь

№	Хийгдэх ажил үйлчилгээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах эзэн
1	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай захирамжаар ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган ажиллах	2022. 03.20	Ажлын төлөвлөгөг гарган ажлын хэсэгт танилцуулсан байна.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
2	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрсдэл бүхий газруудад түймэр гарах бүлзөшгүй улиралд чанартай зохион байгуулах	2,3 дугаар улиралд	Хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгаж зөвлөгөө зөвлөмж хүргүүлсэн байна.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар
3	Ойн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг ард иргэдэд зохион байгуулах	2,3,4 -р улиралд	Нийт 50 иргэнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага тараасан байна.	Ажлын хэсэг
4	Ангийн бүс нутаг болон ой сан бүхий газруудад идэвхтэн байгаль хамгаалагчтай хамтран хууль бус ашиглалтаас урьдчилан сэргийлж хөдөлгөөнт эргүүл хийх	2,4 дүгээр улиралд	“Жинст хайрхан”, “Эх элбэг” ангийн бүс нутгууд болон Хавцгайн хөндий, Хөнөгийн заган ойд идэвхтэн байгаль хамгаалагчдыг хөдөлгөөнт эргүүл	Байгаль орчны тогтвортой хөгжлийн тасаг

			хийлгэж хэвшсэн байна.	
5	Хөнөг багийн заган ойд мэдээллийн самбар байрлуулах	3 дугаар улиралд	Ойн сан бүхий газарт 4-5 ширхэг мэдээллийн самбар байршуулна.	Ажлын хэсэг
6	Ойн сан бүхий газарт нутагладаг айл өрхүүдэд Ойн тухай хууль болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийж гарын авлага тараах	2,3 дугаар улиралд	Нийт 500 ш гарын авлага тараасан байна.	Ажлын хэсэг
7	Заг бүхий нутагт хууль бусаар заг бутлаг ургамал түлшинд хэрэглэхэд хяналт тавьж ажиллах	4-р улиралд	Хөнөгийн заган ойд хууль бус тээвэрлэлтэнд 2 удаа хяналт шалгалт хийгдсэн байна	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар



Сумын Засаг даргын 2022 оны 03  
дүгээр сарын 31-ны өдрийн 1/50 тоот  
захирамжийн 2 дугаар хавсралт

ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХАРГА  
ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хэрэгжүүлэх ажил үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Гарын авлага бэлтгэх	ш	500	500	25000
2	Шатахуун /Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд/	Литр	100	2550	255000
3	Анхааруулга самбар, тэмдэглэгээ хийх	ш	5	10000	50000
Нийт дүн – 330.000					

-----oO-----